



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ADB
ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ ЗӨВЛӨМЖ

УРАН ЗОХИОЛ

УЛААНБААТАР 2021



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



THE WORLD BANK
IBRD • IDA | WORLD BANK GROUP



ADB ASIAN
DEVELOPMENT
BANK



БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
БОЛОВСРОЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТӨВ

БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН
ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ
ШАЛГУУРЫГ ХЭРЭГЛЭХ

ЗӨВЛӨМЖ

УРАН ЗОХИОЛ

АНХНЫ ХЭВЛЭЛ

УЛААНБААТАР 2021

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Суралцагчийн үнэлгээ.....	2
---------------------------	---

БҮРЭН ДУНД БОЛОВСРОЛЫН ТҮВШИН

Нэг. Уран зохиолын бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн онцлог	5
--	---

Хоёр. Шалгуурт суурилсан үнэлгээ	7
--	---

2.1. Нэгж хичээл ба үнэлгээний нэгж	7
---	---

2.2. Суралцахуйн зорилт ба суралцахуйн үр дүн	10
---	----

2.3. Үнэлгээний шалгуур ба гүйцэтгэлийн түвшин	11
--	----

Гурав. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар	19
---	----

3.1. Үнэлгээний даалгавар боловсруулах нь	19
---	----

3.2. Нэгж хичээлийн үнэлгээний даалгаврын жишээ	21
---	----

Дөрөв. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал.....	23
--	----

СУРАЛЦАГЧИЙН ҮНЭЛГЭЭ

Боловсролын үнэлгээний нэг чухал хэсэг нь суралцагчийн үнэлгээ юм. Энэ нь суралцагчийн суралцах үйл ажиллагаа /суралцахуй/-ны талаарх мэдээлэл цуглуулах, сайжруулах, шаардлагатай тохиолдолд шийдвэр гаргах зорилгоор системтэй мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийх, үнэлэлт дүгнэлт хийх үйл явц юм. Багш нар хичээл сургалтын явцад суралцагчийг үнэлж журналд дүн тавих, нэгж, бүлэг сэдвийн дараа шалгалт /сорилго¹/ авах, засаж оноожуулах /хэмжилт хийх²/, үнэлж дүгнэх³ зэрэг байнга хийдэг ажил нь үнэлгээний үйл явцад хамаарна.

Бид үнэлгээний шалгалт авах, дүн тавих үйл явцыг хийдэг боловч шалгалтаар дамжуулан суралцахуйн талаар ямар ач холбогдолтой мэдээлэл цуглуулж буй, үр дүнд шинжилгээ хийх, шинжилгээний үр дүнг сургалтын үйл ажиллагаанд бүтээлчээр хэрэглэх байдлыг орхигдуулж ирсэн. Суралцагчийн үнэлгээг зөвхөн дүн тавихын тулд хийж ирсэн тогтсон ойлголт, хандлагыг өөрчлөх хэрэгцээ байна.

Суралцагчийн үнэлгээ гэдэгт “суралцагчийн сурлагын амжилтын түвшнийг тогтоох, мэдлэг, чадвар, хандлага төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг бодитой үнэлэх, түүнд тулгарч буй бэрхшээлийг илрүүлж дэмжлэг үзүүлэх, урамшуулах үйл явц”-ыг ойлгоно.

Хичээл, сургалтын өдөр тутмын болон тодорхой хугацааны /бүлэг сэдэв, хагас жил, жилийн эцэс/ дараа хийдэг бүх төрлийн үнэлгээ “шалгуур”-т суурилсан байна.

ШАЛГУУРТ СУУРИЛСАН ҮНЭЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР

Багш нарын хувьд “үнэлгээ”-г шалгуурт суурилсан байдлаар үр дүнтэй хийхийн тулд үнэлгээний шалгуур болон шалгуурт суурилсан үнэлгээний талаарх мэдлэг ойлголтоо өргөжүүлэн гүнзгийрүүлэх шаардлагатай.

Суралцахуйн үр дүнд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшилд баримжаалж боловсруулсан тодорхой шалгуур (хүрэх үр дүн)-тай харьцуулж суралцагчийн сурлагын амжилтыг үнэлэх үйл явцыг шалгуурт суурилсан үнэлгээ /criterion referenced assessment/ гэдэг. Өөрөөр хэлбэл суралцагчийн гүйцэтгэлийг бусад суралцагчтай бус зөвхөн үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлж, дүгнэх үйл явц гэсэн үг.

Үнэлгээний шалгуур нь:

- Суралцахуйн үр дүнд нийцсэн сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн тодорхойлохыг зааж өгдөг.
- Сурагч суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юуг хийж чадаж байгаагийн товч илэрхийлэл
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

¹ Сорилго нь бүх суралцагчдыг тодорхой хугацааны дараа зохион байгуулдаг, асуултын багцаас тогтсон үнэлгээний тодорхой төрөл юм. Сорилго нь тоон болон ямар нэг ангиллын хэмжээсийг ашиглан суралцагчийн нэг ба хэд хэдэн шинж чанарыг хэмжих, илэрхийлэх гэсэн системтэй арга хэрэгсэл юм.

² Хэмжилт нь сорилго, эсвэл үнэлгээний төрлийн үр дүнг тусгай дүрэм (жишээлбэл, зөв хариулыг тоолох, оноо өгөх г.м)-ийн дагуу тоогоор илэрхийлдэг. Ихэнхдээ оноо өгөх /scoring/ гэж тодорхойлдог.

³ Үнэлгээний мэдээллийг хэрэглэн, тогтсон шалгуур үзүүлэлтэд харгалзах чансааг тодорхойлох үйл явц

Өөрөөр хэлбэл, үнэлгээний шалгуур гэдэг нь сургалтын явцад суралцагч бүрийн эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага төлөвшил буюу хүрэх үр дүн юм.

Үнэлгээний шалгуур нь дараах ач холбогдолтой. Үүнд:


- Суралцагчийн сурлагын амжилтыг үнэлж, дүгнэх ижил хэмжүүрийг тодорхой, ил тод болгох.
- Үнэлгээг зөв, бодитой хийх боломж бүрдэх.
- Даалгавар боловсруулахад баримжаа болох.
- Тухайн суралцагчийн суралцахуйн давуу, сул тал, тулгамдаж буй бэрхшээлийн талаарх мэдээллийг цуглуулах.
- Суралцахуйн арга зүйг төлөвлөх, хэрэгжүүлэх замаар багшлахуйг сайжруулах боломжийг бүрдүүлэх.
- Суралцагчийг ижил шалгуураар үнэлж, тэдний ахиц амжилт, өөрчлөлтийг хянах боломж олгох.

Үнэлгээний шалгуур нь дараах шаардлагад⁴ нийцсэн байна. Үүнд:


- Боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх
- ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулсан байх
- Оролцогч бүх тал /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичсэн байх
- Давхцалгүй, нэг нэгнээсээ ялгаатай байх
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: эмхэтгэх, бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, тайлбарлах, урьдчилан таамаглах, харьцуулах, шүүмжлэх гэх мэт
- Сурагчийн гүйцэтгэл нь ажиглагдахуйц, хэмжигдэхүйц байхаар үг сонгох

ХИЧЭЭЛ, СУРГАЛТЫН ҮР ДҮНГ ҮНЭЛЭХ ШАЛГУУРЫН БҮТЭЦ

Ерөнхий боловсролын сургуулийн түвшинд хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнд тулгуурлан дараах бүтэцтэйгээр боловсруулсан.



⁴ Эх сурвалж: Боловсролын салбарын хөгжил-Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс” судалгааны эцсийн тайлан, 1.14 дэх бүлэг. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны төсөл, 2017 он.



Нэг. Уран зохиолын бүрэн дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн онцлог

Аман ба бичгийн хэлний хэм хэмжээг судлан эзэмшиж, харилцааны соёл, хэлний мэдрэмж, авьяас болон оюун санаа, сэтгэлгээгээ хөгжүүлэн, үндэсний хэл, бичиг, өв соёл, оюуны үнэт зүйлсийг эрхэмлэдэг монгол иргэн болж төлөвшихөд уран зохиолын хичээл чухал үүрэгтэй.

- ✓ Бага боловсролын түвшинд **уншигчийн сэтгэл хөдлөлд суурилсан уншлагыг** чухалчилж, суралцагчдын тусган хүлээж авах чадварыг хөгжүүлэх
- ✓ Суурь боловсролын түвшинд **бичвэрт төвлөрсөн уншлага** буюу зохиолыг задлан шинжлэх арга зүйг суралцахуйн арга барилд хялбаршуулан буулгах замаар суралцагчдад чадвар эзэмшүүлэх
- ✓ Бүрэн дунд боловсролын түвшинд **зохиогч ба хам сэдэвт төвлөрсөн уншлага** өрнүүлж, уншигчийн тайлал тайлбарыг хөгжүүлэх замаар сэтгэгч-уншигч болгохыг зорьж байгаа билээ. Уран зохиолын хичээлийн суралцахуйн суурь ба бүрэн дунд боловсролын зорилт:

Агуулгын ай	Суурь				Бүрэн дунд			Бүрэн дунд /сонгон/		
	VI	VII	VIII	IX	X	XI	XII	X	XI	XII
Унших	7	7	7	7	7	7	7	3	4	6
Бичих	3	3	2	2	2	2	2	2	2	2
Ярих-сонсох	2	2	1	1	1	1	2	1	1	1
Бүгд	12	12	10	10	10	10	11	6	7	9
	49				31			22		

Уран зохиолын суралцахуйн зорилт 31 /заавал судлах/ буй бөгөөд хичээл сургалтын үйл ажиллагааг төлөвлөх, удирдаж чиглүүлэх, зааж хэрэгжүүлэх, үнэлгээ дүгнэлт хийх зэрэгт мөрдлөг болгож байгаа билээ. Түүнчлэн уран зохиолын хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг боловсруулахдаа ч суралцахуйн зорилтыг баримталсан.

Бүрэн дунд боловсролын уран зохиолын хичээл дараах онцлогтой.

- ✓ Хувийн туршлагатай, бичвэрт суурилсан задлан шинжлэх арга барилтай, хам сэдвийн хүрээнд далд утгыг тайлбарладаг уншигчид бэлтгэгдсэн байдаг.
- ✓ Өөр өөр цаг үеийн уянга, туульс, жүжгийн шүлэглэсэн болон үргэлжилсэн үгийн хэлбэрээр бичсэн түүх, соёл, нийгмийн онцлог байдал, үндэсний ухамсар, ёс суртахууны суурь үнэт зүйлсийг хамгаалсан сэдэвтэй, цагийн шалгарлыг давж үнэлэгдсэн зохиолуудаас судалдаг.
- ✓ Өрнө дорнын нийгэм соёлын олон янз байдлыг тусгасан, хүний эрх, эрх чөлөө, ёс суртахууны суурь үнэт зүйлсийг хамгаалсан сэдэвтэй, шилдэг бүтээлүүдийг уншдаг.
- ✓ Зохиолоо уншсаны дараа зохиогчийн туршлагыг нээн илрүүлэх задлан шинжлэх үйл ажиллагаа буюу судалгаат уншлагад хөтөлдөг.
- ✓ Хам сэдэвт төвлөрсөн судалгаа буюу хам сэдвийн хүрээнд далд утгыг тайлан тайлбарладаг шүүмжлэлт ба бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэхэд чиглэдэг.
- ✓ Зохиолын үндсэн бүтвэр болох өгүүлэгдэхүүн/ үйл явдал, дүр, сэдэв/утга, дүр, орчин, хэл найруулгын онцлогт тулгуурлахаас гадна, тэдгээрийн холбоо хамаарал, уншигчид нөлөөлөх нөлөөллийг судалж, уншигчийн тайлал тайлбарыг хөгжүүлдгээрээ бусад судлагдахуунаас ялгардаг онцлогтой.
- ✓ Суралцахуйн зорилтод тулгуурласан үр дүн нь бүхэллэг бөгөөд нэгж хичээл бүрээр дахин давтан хэрэгжихээр томъёологдсон. Тухайлбал: 10.1б, 10.1в, 10.1г, 10.1д, 10.1ж, 10.2а, 10.2б; 11.1б, 11.1в, 11.1г, 11.1д, 11.1ж, 11.2а, 11.2б; 12.1б, 12.1в, 12.1г, 12.1д, 12.1ж, 12.2а, 12.2б, 12.3а

Уран зохиолын хичээл нь унших, ярих, сонсох, бичих үйлийн нэгдэл учраас нэгж /сургалтын тодорхой үйл ажиллагаа явуулсны/ хичээлийн дараа зорилгодоо хүрсэн эсэхийг тогтоохын тулд сурагч бүрийн чадвар, дадал, хандлага, мэдлэг чадварын ахиц амжилтыг тооцоход “Хичээлийн сургалтын үр дүнг үнэлэх шалгуур” нь баримтлах баримт болно. Мөн үнэлж дүгнэхдээ зохиолыг тусган хүлээн авснаа амаар буюу бичгээр илэрхийлж буй чадварыг; зохиолыг задлан шинжилж тайлан тайлбарлаж, бүтээлчээр сэтгэж буй чадварыг; шүлэглэсэн зохиолын онцлогийг таньж мэдсэн чадвар; санаа бодлоо илэрхийлэн мэтгэлцэх зэргийг шалгуураар үнэлнэ.

Үнэлгээний шалгуурт тавигдах ерөнхий шаардлага нь:

- Үнэлгээний шалгуур нь хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй нийцэж байх.
- Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг илрүүлэхүйц, хэмжихүйц байх
- Үнэлгээний шалгуур нь давхцаагүй, нэг нэгнээсээ ялгаатай байх.
- Үнэлгээний шалгуур нь боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх.
- Үнэлгээний шалгуур нь ЕБС-ийн багш нар шууд авч ашиглах боломжтой байхаар боловсруулагдсан байх. Оролцогч бүх талууд /суралцагч, багш, эцэг эх, асран хамгаалагч гэх мэт/-д ойлгогдохоор товч тодорхой, оновчтой энгийн үг хэллэгээр бичигдсэн байх.
- Суралцагчдад юу хийхийг тодорхой ойлгуулахуйц үйл /түлхүүр үг/ үгсийг ашигласан байх. Жишээ нь: бий болгох, бүтээх, төлөвлөх, дахин боловсруулах, шинжлэх, дизайн хийх, сонгох, ашиглах, хэрэглэх, үзүүлэх, бэлтгэх, ашиглах, тооцоолох, хэлэлцэх, тайлбарлах, урьдчилан таамаглах, үнэлэх, харьцуулах, шүүмжлэх гэх мэт.

Хоёр. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар

2.1. Нэгж хичээл ба үнэлгээний нэгж

НЭГЖ ХИЧЭЭЛ, ҮНЭЛГЭЭНИЙ НЭГЖ хоёр нь өөр ойлголт гэдгийг ойлгох нь чухал.

Бүрэн дунд боловсролын Уран зохиолын хичээлийн хөтөлбөрийн агуулга нь:

Унших

Бичих

Ярих-сонсох айтай. Агуулга тус бүр нь зорилттой. Мөн тухайн ангийн “Уран зохиол”-ын сурах бичиг зохиолын төрөл зүйл /домог, аман яруу найраг, шүлэг, өгүүллэг гэх мэт/-ээр юм уу, эсвэл эртний уран зохиол, орчин үеийн яруу найраг, орчин үеийн хүүрнэл зохиол, гадаадын уран зохиол гэх мэт дарааллын онцлогийг харгалзсан байдаг. Ихэвчлэн сурах бичгийн агуулгад тулгуурлан нэгж хичээлийг төлөвлөж, түүндээ унших, бичих, ярих, сонсох чадварыг багтаан нэгжилдэг. Жишээ нь: ЕБС-ийн сургалтын төлөвлөгөөнд 10-р ангийн Уран зохиолын хичээлийг долоо хоногт 1 цаг, жилд 33 цаг заахаар тусгасан байгаа. Нэгж хичээлийг “Уран зохиол Х” сурах бичгээр баримжаалсан хуваарилалт:

Суралцахуйн зорилтууд /кодоор/ Монголын эртний уран зохиол		I бүлэг	II бүлэг	III бүлэг	IV бүлэг
		Өгүүллэг	Яруу найраг	Жүжиг	
Унших	10.1а.	+	+	+	+
	10.1б.	+	+	+	+
	10.1в.	+	+	+	+
	10.1г.	+	+	+	+
	10.1д.	+	+	+	+
	10.1е.	+		+	
	10.1ж.	+	+	+	+
Бичих	10.2а.	+	+	+	+
	10.2б.	+	+		
Ярих,сонсох	10.3а.	+	+		+
Судлах цаг		9	8	8	8

Сургалт нь мэдлэг бүтээх, чадвар эзэмшүүлэх нь бүхэл бүтэн дидактик үйл ажиллагаа тул сургалтын зорилгоо дидактик нэгж байдалтай томъёолдог. Өөрөөр хэлбэл бүлэг сэдвээ нэгж хичээлүүдэд, нэгж хичээлээ ээлжит хичээлүүдэд, ээлжит хичээлээ дидактик алхмуудад хуваадаг.

Тэгвэл зорилго нь:

- Бүлэг сэдвийн зорилт нь нэгж хичээлүүдийн зорилтоос
- Нэгж хичээлийн зорилт нь ээлжит хичээлийн зорилтуудаас
- Ээлжит хичээлийн зорилт нь дидактик алхмуудын зорилтоос тогтох байдлаар шатлан эрэмбэлүүлж тодорхойлдог. Лавшруулбал сургалтын хөтөлбөрийн агуулгыг дидактик нэгжид хуваасан шийдэл бүхий төлөвлөлт бол нэгж хичээл юм.

Нэгж хичээл нь:

- ✓ Үйл ажиллагааны зорилтоо тодорхойлсон
- ✓ Сурагчдад юуг, хэзээ, яаж сурахыг мэдээлсэн
- ✓ Сурагчдын үүрэг хариуцлагыг тодорхойлсон
- ✓ Агуулгаа элментарчилсан
- ✓ Үнэлгээ нь зорилго, зорилттойгоо нийцсэн
- ✓ Үнэлгээний шалгуураа гаргаж хүүхдэд тодорхой танилцуулсан цогц шийдэл бүхий баримт юм.

Тэгвэл бидэнд суралцахуйн үр дүнгийн үнэлгээ түүний шалгуур учир дутагдалтай байсныг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж байна. Тиймээс шинэ зүйл мэт хүлээж авах биш, хийж хэрэгжүүлж байсан зүйлийг шинэчлэн нэгдсэн ойлголтод хүргэж байгаа юм.

Уран зохиолын хичээлийн үнэлгээний нэгж:

Нэгж хичээл нь сургалтын хөтөлбөрийн агуулгыг томсгосон дидактик нэгжид хуваасан шийдэл бүхий агуулгын хуваарилалт бол үнэлгээний нэгж нь тухайн ангийн агуулгын хувьд сурагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг илрүүлэн дүгнэх шалгуурыг нэгтгэсэн үнэлэх агуулгын багц шинжтэй шийдэл юм.

Бүрэн дунд боловсролын Уран зохиолын хичээлийн хүрээнд:

Зохиолыг уншиж ойлгох

Зохиолыг задлан шинжлэх

Шүлэглэсэн зохиолын онцлог гэж нэгжилсэн бөгөөд анги тус бүрийн агуулгатай уялдуулан ихэнхийг нь багцалсан.

X анги

Агуулгын ай	№	Үнэлгээний нэгж	Холбогдох суралцахуйн зорилтын код
Унших		Зохиолыг уншиж агуулгыг ойлгох	10.1a.10.3a
Бичих		Зохиолыг задлан шинжлэх	10.1б,10.в,10.1г, 10.1д,10.1ж,10,2а, 10.2б
Ярих,сонсох		Шүлэглэсэн зохиол	10.1e.

XI анги

Агуулгын ай	№	Үнэлгээний нэгж	Холбогдох суралцахуйн зорилтын код
Унших	1.	Зохиолыг уншиж агуулгыг ойлгох	11.1a.11.3a
Бичих	2.	Зохиолыг задлан шинжлэх	11.1б,11.в,11.1г, 11.1д,11.1ж,11,2а, 11.2б
Ярих,сонсох	3.	Шүлэглэсэн зохиол	11.1e.

XII анги

Агуулгын ай	№	Үнэлгээний нэгж	Холбогдох суралцахуйн зорилтын код
Унших	1.	Зохиолыг уншиж агуулгыг ойлгох	12.1a.12.3a
Бичих	2.	Зохиолыг задлан шинжлэх	12.1б,12.в,12.1г, 12.1д,12.1ж,12,2а, 12.2б,12.3б
Ярих,сонсох	3.	Шүлэглэсэн зохиол	12.1e

Ийнхүү үнэлгээний нэгжийг тогтоохдоо дараах зарчмыг баримталсан. Үүнд:

- ✓ Сургалтын хөтөлбөрийн өөр өөр агуулгын айн ижил төрлийн зорилтуудыг хооронд нь нэгтгэж суралцахуйн нэг үр дүн болгосон. Жишээ нь:

Суралцахуйн зорилт	Суралцахуйн үр дүн
11.1a. Өрнө дорны өөр өөр соёлын уран зохиолоос уншиж, хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлэх замаар нийгэм, соёлын олон янз байдлыг ойлгох 11.3a.Уншсан зохиолын хам сэдвийн хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн хэлэлцэх	Зохиолыг тусган хүлээн авснаа /амаар буюу бичгээр/ илэрхийлдэг болсон байна.

Энэ нь 11-р ангийн “Зохиолыг уншиж агуулгыг ойлгох” буюу “Үнэлгээний нэгж 1”-г бий болгосон.

- ✓ Дахин давтах шаардлагагүй агуулгыг тус тусад нь үнэлгээний нэгж болгосон. Жишээ нь: X, XI, XII ангийн “Шүлэглэсэн зохиол” үнэлгээний нэгжид “Яруу найргийн онцлогийг тайлбарладаг болсон байна” гэсэн үр дүн байх ба “Яруу найргийн онцлогийг тайлбарладаг” гэсэн шалгуурыг ээлжит хичээл бүрд хэрэглээд байх боломжгүй.
- ✓ Бүрэн дунд боловсролын уран зохиолын хичээлээр зохиолыг задлан шинжилж, тайлан тайлбарлах арга зүйг эзэмшүүлэх нь чухал учраас суралцахуйн ихэнх зорилтыг нэгтгэж “Зохиолыг задлан шинжлэх” нэгжид хамруулсан.
- ✓ Дарааллыг баримталсан. Зохиолыг уншиж ойлгосны дараа санаа бодлоо илэрхийлэх, задлан шинжлэх, илтгэх, мэтгэлцэх гэх мэт.
- ✓ Түүнчлэн үнэлгээний нэгжийн шалгуур тус бүрийг нэгж, ээлжит хичээлд ижил хэрэглэх боломжгүй бөгөөд соёл, түүх, нийгмийн хам сэдвийн хүрээнд мэдэрч, тусган хүлээн авсны дараа тохирох шалгуурыг сонгож хэрэглэнэ.

2.2. Суралцахуйн зорилт ба суралцахуйн үр дүн

Суралцахуйн зорилт бол сурагчдын тухайн хичээлээр судалж эзэмших мэдлэг, чадварын илэрхийлэл юм. XI ангид унших-7, бичих-2, ярих-сонсох-1, бүгд -10 суралцахуйн зорилт байгаа болно. Анги бүрээр товчоолж харьцуулбал:

Агуулга	Унших	Бичих	Ярих-сонсох	Нийт
X анги	7	2	1	10
XI анги	7	2	1	10
XII анги	7	2	2	11
Нийт	21	6	4	31

Суралцахуйн үр дүн: Тухайн хөтөлбөрийн төгсгөлд сурагчдын олж авах ёстой мэдлэг, ур чадвар яагаад тэдэнд ашигтай болохыг ойлгоход нь туслах зорилготой.

Дараах шаардлагад үндэслэн суралцахуйн үр дүнг тодорхойлсон болно.

1. Сургалтын хөтөлбөрийн агуулгаас хэд хэдэн суралцахуйн зорилтыг нэгтгэж ерөнхийлсөн. /Нэгтгэсэн зорилтуудыг онцолсон/

Суралцахуйн зорилт /кодоор/	Суралцахуйн үр дүн
10.1a.10.3a	Зохиолыг тусган хүлээн авснаа /амаар буюу бичгээр/ илэрхийлдэг болсон байна.
10.1б,10.в	Зохиолын бүтэц, хүүрнэлийн холбоо хамаарал ба дүрийн шинжийг тайлбарладаг болсон байна.
10.2б	Зохиолын орчин нь дүрд нөлөөлж буйг тодорхойлдог болсон байна.
10.1г	Зохиолын уншигчид үзүүлэх нөлөө ба далд утгыг тайлан тайлбарладаг байна.
10,2a,	Зохиолын орчин нь дүрд нөлөөлж буйг тодорхойлдог болсон байна.
10.1д, 10.1ж	Зохиолын хэл найруулгын нөлөө ба хэлний хэрэглээг үнэлж дүгнэдэг болсон байна.
10.1e.	Яруу найргийн онцлогийг тайлбарладаг болсон байна.

XI анги

Суралцахуйн зорилт /кодоор/	Суралцахуйн үр дүн
11.1a.11.3a	Зохиолыг тусган хүлээн авснаа /амаар буюу бичгээр/ илэрхийлдэг болсон байна.
11.1б,11.1в,11.г	Зохиолын өгүүлэгдэхүүн ба зохиомжийн нэгжүүдийн уялдаа холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлох. Зохиолын дүрийн бодгаль ба нийтлэг шинж нь утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлдог.
11.1д	Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүр ба сэдвийг тодруулахад нөлөөлж буйг тодорхойлдог.
11,1ж	Сэдэв, утга санаа, хам сэдвийн хамаарлаар далд утгыг тайлан тайлбарладаг.
11.2a, 11.2б	Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг тайлдаг.
11.1e.	Яруу найргийн онцлогийг тайлбарладаг болсон байна.

XII анги

Суралцахуйн зорилт /кодоор/	Суралцахуйн үр дүн
12.1а,12.3а	Зохиолыг тусган хүлээн авснаа /амаар буюу бичгээр/ илэрхийлдэг болсон байна.
12.1в,12.1г	Зохиолын бүтэц, зохиомжийн нэгж ба дүрийн хэв шинжийг дүгнэж, тайлбарладаг болсон байна.
12.1д	Зохиолын орчин нь дүрд нөлөөлж буйг задлан шинжилдэг болсон байна.
12.1б, 12.1ж	Зохиолын уншигчид үзүүлэх нөлөө ба далд утгыг тайлан тайлбарладаг байна.
12,2а, 12.2б,12.3б.	Зохиолын хэл найруулга, хэлний хэрэглээнээс суралцдаг болсон байна.
12.1е.	Яруу найргийн онцлогийг тайлбарладаг болсон байна.

- Суралцахуйн зорилтын үндсэн агуулгыг алдагдуулахгүй, нэмж хасахгүйгээр суралцахуйн үр дүн болгосон бөгөөд энэ хоёрыг ижил түвшинтэй байхаар томъёолсон.
- Суралцахуйн үр дүн нь сурах үйл явцыг бус ямар үр дүнд хүрэхийг хоёрдмол санаагүй, шууд ойлгогдохоор тодорхойлсон. Жишээ нь: 10-р ангид “Зохиолын хэл найруулгын нөлөө ба хэлний хэрэглээг үнэлж дүгнэдэг болсон байна” гэсэн нь сурагчид зохиолын хэл найруулга, хэлний хэрэглээг судлах, мэдэх ёстой юм байна гэсэн үр дүнгийн мэдээллийг өгч байна.
- Суралцахуйн үр дүн нь тухайн хөтөлбөрийн хүрээнд эзэмших шаардлагатай хүлээсэн мэдлэг, тусгай болон ерөнхий чадвар, үнэт зүйл, хандлагад чиглэсэн байх ёстой.
- Суралцахуйн үр дүн нь хэмжигдэхүйц, ажиглагдахуйц байх.
- Үнэлгээний шалгуур нь давхцаагүй, нэг нэгнээсээ ялгаатай байх. Жишээ нь:

“Зохиолын орчин” бол бүхий л ангид байгаа боловч агуулгын гүнзгийрэл, мэдлэг чадвар эзэмших ахицаар ялгарч байгаа.

	Үнэлгээний шалгуур
X анги	Зохиолын орчин нь дүрд нөлөөлж буйг тодорхойлдог болсон байна.
XI анги	Зохиолын орчин нь дүр ба сэдэвт нөлөөлж буйг тодорхойлдог болсон байна.
XII анги	Зохиолын орчин нь дүрд нөлөөлж буйг задлан шинжилдэг болсон байна.

- Үнэлгээний шалгуур нь боловсролын түвшин, анги, судлагдахуун бүрээр залгамж холбоотой, эрэмбэ ахисан байх. Дээрх хүснэгтээс ажиглавал **тодорхойлдог, нөлөөлж буйг тодорхойлдог, нөлөөлж буйг задлан шинжилдэг** гэх мэт үйл үгээр залгамж холбоо, эрэмбэ ахиж буй нь харагдаж байна. Анги бүрийн үнэлгээний шалгуурын үйл үгийг ажиглаж, үнэлж дүгнэхдээ ч нарийн анзааран хэрэглэнэ.

2.3. Үнэлгээний шалгуур ба гүйцэтгэлийн түвшин

- Шалгуур (criterion) нь суралцагчийн хүрсэн үр дүн буюу амжилтыг нотлон харуулахад чиглэсэн үзүүлэлт юм. Түүнчлэн сурагчийн хувьд хүрсэн үр дүн, амжилтыг харуулахын тулд юу хийх ёстойг илэрхийлдэг бол багш нарын хувьд юуг сургасан байх ёстой вэ гэдгийг тодорхойлдог.
- Гүйцэтгэлийн үзүүлэлт /Achievement Standard, Performance Standard/ бол чанарын тодорхой түвшний /гүйцэтгэл/ тухай ойлголт юм.

Багшийн хувьд:

- Юуг сургасан байх ёстой вэ гэдгийг илэрхий тодорхой болгосон.
- Сурагчийн гүйцэтгэлийг хэрхэн яаж, юугаар тодорхойлох, үнэлэх, дүгнэхийг ойлгомжтой болгосон.
- Сурагчийг бусад сурагчтай бус үнэлгээний шалгууртай харьцуулж үнэлнэ. Өөрөөр хэлбэл тэр сурагч тийм, минийх ийм гэх мэт үнэлгээний талаар зөрчил маргаан үүсэхгүй.


Сургалтын бодит байдлыг тогтоож үнэлэлт, дүгнэлт хийх чухал баримт болно.

Сурагчийн хувьд:

- Суралцахуйн үр дүнг амжилттай эзэмшсэнийг харуулахын тулд юу хийх ёстойг тодорхой харуулдаг.
- Шалгуур нь суралцагчийн хүссэн үнэлгээндээ хүрэхийн тулд ахиц дэвшлийг эрэмбэлсэн үзүүлэлт болж өгдөг.
- Суралцахуйн үр дүн бүрийг эзэмшсэн байх тодорхой, хоёрдмол утгагүй нотолгоог бий болгох зорилготой.

Сурагчдын амжилтыг хэмжих **шалгуурын** талаар тэдэнд сайн ойлголт өгөх ёстой. Анги танхимд шалгуураа байршуулж, харуулах нь сурагч ахиц дэвшлийнхээ талаар ерөнхий ойлголттой болоход тусална. Тодорхой асуудлын хүрээнд үйл явцыг харуулсан мэдээлэл өгч, хэр хандаж байгаа болон хаана явааг /гүйцэтгэлийн түвшний/ нь сануулж, сурах үйл ажиллагааг нь чиглүүлэх боломжтой. Сурагчид ч цаашид юу хийх, хаана хүрэхээ төлөвлөх, тооцоолох, бэлтгэх боломжийг олгодог.

Үнэлгээ нь ямар нэг зүйлийн үнэ цэн, ач холбогдолтойг дүгнэхүйн үйл явц.



Үнэлгээний шалгуур ба гүйцэтгэлийн түвшний тухай гүнзгийрүүлэн ойлгохын тулд 11 дүгээр ангийн жишээгээр авч үзье.

д/д	Нэгж	Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур
1.	Зохиолыг уншиж агуулгыг ойлгох	<input type="checkbox"/> Зохиолыг хам сэдвийн хүрээнд тусган, эргэцүүлснээ илэрхийлдэг. <input type="checkbox"/> Уншсан зохиолын хүрээнд үзэл бодлоо илэрхийлдэг <input type="checkbox"/> Нийгэм соёлын олон янз байдлыг ойлгосноо илэрхийлдэг.
2.	Зохиолыг задлан шинжлэх	<input type="checkbox"/> Зохиолын өгүүлэгдэхүүн ба зохиомжийн нэгжүүдийн уялдаа холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлдог. <input type="checkbox"/> Зохиолын дүрийн бодгаль ба нийтлэг шинж нь утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлдог. <input type="checkbox"/> Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүр ба сэдвийг тодруулахад нөлөөлж буйг тодорхойлдог. <input type="checkbox"/> Сэдэв, утга санаа, хам сэдвийн хамаарлаар далд утгыг тайлан тайлбарладаг. <input type="checkbox"/> Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг тайлдаг. <input type="checkbox"/> Зохиолыг шинжлэхдээ холбогдох нэр томъёог хэрэглэн бичдэг. <input type="checkbox"/> Яруу найргийн хэлбэр бүтцийг дуурайн, тодорхой сэдвийн хүрээнд дүрслэн зохиодог.
3.	Шүлэглэсэн зохиол	<input type="checkbox"/> Яруу найргийн хэлбэр, бүтцийг шинжилдэг.

Харин үр дүнг хэмжих шалгууруудын ихэнх нь “Зохиолыг задлан шинжлэх” нэгжид хамаарч байна. Тэгэхлээр ахлах ангийн суралцагчийн /уншигчийн/ тайлан тайлбарлах чадварыг хөгжүүлэхэд суралцахуйн үр дүнгийн шалгуур чиглэсэн байна. Иймээс бид хүрэх үр дүн, шалгуураа нээлттэй, ил тод байлгаснаар зорилго чиглэлийг нь тодорхой болгож байгаа юм. Ингэснээрээ тэднийг бүтээлч болгоход үр дүнгийн шалгуур дэмжлэг болно.

Тэгвэл багшийн зүгээс хэрхэн ажиллах, яаж үнэлж дүгнэх вэ гэдэг асуудал үнэндээ арга барил, ур чадвар шаардана. Мэдээж эх зохиолоо уншиж хүлээн аваагүй тохиолдолд ямар задлан шинжлэл хийх билээ, яаж үнэлэх билээ. Сурагчид зохиол /бүтээл/-оо хэр уншсан, хэрхэн хүлээн авсныг илрүүлэх аргыг ашиглан, амаар буюу бичгээр шинжилж, үнэлгээ хийхээ төлөвлөнө.

Мэдлэг /Блум/	Эх зохиол уншсаныг /мэдээлэл хүлээн авсныг/ шинжих	Эх зохиолоо хэрхэн уншсан
Баримтын мэдлэг	<ul style="list-style-type: none"> - Бүхэлд нь гүйлгэн уншсан - Зохиолын агуулгыг бусдаар яриулсан - Ерөнхийлөн тоймлох хэлбэрээр уншсан - Зарим хэсгийг алгасан уншсан - Эх зохиолыг сонсож уншсан /эх сурвалж: youtube, cd гэх мэт/ 	Аман үнэлгээ /багш сурагчаа зохиол /бүтээл/ ямар хэмжээнд уншсан /үзэж судалсан/-ыг эдгээр асуултаар шинжилж болно.
Ухагдахууны мэдлэг	<ul style="list-style-type: none"> - Хэсэглэн уншсан /чухал зүйлийг тогтоох зорилгоор/ - Зохиолыг уншихдаа товч тэмдэглэл хийж уншсан - Түлхүүр үгсийг түүвэрлэн тэмдэглэх, ялгах аргаар уншсан 	
Үйлийн мэдлэг	<ul style="list-style-type: none"> - Уншихдаа схем, зураглал, түлхүүр бичиглэл хийсэн - Эх зохиолыг уншихдаа өнгийн тодруулагч хэрэглэж өөртөө шаардлагатай хэсгийг ялгаж, онцолсон - Зохиолыг хувиргасан бүтээлтэй харьцуулан уншсан 	
Танин мэдэх үйлийг жолоодох мэдлэг /метакогнитив/	<ul style="list-style-type: none"> - Тэмдэглэл /зохиолыг бусдадаа ярьж өгөхүйц/ хийж, илтгэх зорилготой уншсан /бүтээлч, идэвхтэй уншлагын хэлбэр/ - Бүтээлч уншсан /ойр дотнынхонтойгоо яриа өрнүүлж, мэтгэлцсэн/ 	

Оношлох үнэлгээнд үнэлгээний шалгуурыг ашиглах

Сургалт эхлэхээс өмнө буюу сургалтын явцад /улирлын эхэнд юм уу тодорхой бүлэг сэдвийг судлахын өмнө/ суралцагчийн **мэдлэг чадварыг түвшинчилнэ**. Үнэлгээний үр дүнд багш хичээлээ юунаас эхлэх, сурагчид ямар мэдлэг, чадвартай байгааг мэдэх боломж олгоно. Тухайн сэдвээр суралцагчид хангалттай мэдлэг, чадвартай байвал хичээлийн агуулгыг өргөжүүлэн, хүндэвтэр дасгал даалгаврыг сонгоно. Хэрэв суралцагчид хангалтгүй байвал үндсэн ойлголт өгөх, дөхүүлэх ба энгийн болон хөнгөвчилсөн дасгал, давтлагыг гүйцэтгүүлэх зэргээр ажиллах хэрэгтэй болно. Үлгэрлэвэл: Өмнөх ангид судалсан нэг зохиолыг сонгон авч зохиолын хүрээнд сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлж буй чадварыг илрүүлэхийн тогтоохын тулд хэлэлцүүлэг хийнэ гэсэн үг. Мэдээж энэ шалгуураар үнэлнэ гэдгээ нээлттэй байлгана. Зарим идэвхтэй сурагчийн хувьд шалгалтдаа бэлтгэхийн тулд дахин уншиж судална. Нөгөө талаар үнэлгээний шалгуурын дээд түвшинд /IV түвшин/ хүрэхийн тулд бие даасан үйл ажиллагааг идэвхжүүлнэ, ач холбогдол өгнө. Багш сурагчийн ярих дарааллыг тогтоож, өөрөө ажиглалтын аргаар сурагч нэг бүрийг үнэлж, ангийн дунджийг тоон аргаар илэрхийлж гарааны түвшин тогтоож болно. Тухайн анги 34 сурагчтай гэж үзвэл:

I түвшинд: Бусдын санал бодлыг хүлээцтэй сонсдог, сэтгэгдлээ илэрхийлж байгаа - 11

II түвшинд: Уншсан зохиолын хүрээнд асуулт тавьдаг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлж байгаа - 9

III түвшинд: Уншсан зохиолын хүрээнд асуулт асууж, хариулт өгдөг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлж байгаа - 10

IV түвшинд: Уншсан зохиолын хүрээнд шүүмжлэн дүгнэлт өгдөг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж байгаа - 4

Үүнийгээ дүгнэлт хийж баримт болгоод нэг улирлын дараа дахин түвшин тогтоогоод харьцуулалт хийж сурагчийн хөгжил, хичээлийнхээ үр дүнг тооцно. Энэ бол сурагчдаа оношилж байгаа хэрэг бөгөөд гарааны үнэлгээг хялбархан шийдэж буй арга болно.

Нөгөө талаар оношлох үнэлгээг сурах үйл ажиллагаанд гарч буй **бэрхшээлийг олж илрүүлэхэд** ашигладаг. Ангийн ихэнх сурагч гүйцэтгэж чадахгүй байгаа чадвар болон алдаатай хийж гүйцэтгэж буй агуулгыг мэдсэнээр багш тухайн агуулгыг эзэмшүүлэх арга барилаа өөрчилнө. Юунаас шалтгаалаад амжилттай сурахгүй байгааг оношилсноор алдааг засах аргыг олдог. Үүнийг ихэвчлэн нэгж, бүлэг сэдвийн дараа /улирлын эцэст/ хийдэг.

Үүний тулд бүлэг сэдвийн /нэгж/ дараа үнэлгээний шалгуур бүрээр сурагчаа оношилж тогтооно. Жишээлбэл: Х ангийн Зохиолын хэл найруулга уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг тайлдаг гэсэн шалгуурын I,II түвшинд ангийн ихэнх хүүхдүүд хамрагдаж байгаа бол “Зохиолын үг сонголт /уран дүрийн үг/; үгийн сан /шинэ, хуучин, гадаад гм/; уран дүрслэл /адилтгал, егөөдөл, бэлгэдэл гэх мэт/; бичил дүрслэл, яруу хэрэглүүр уншигчдад хэрхэн нөлөөлж буйг жишээ баримтаар тайлдаг” чадварын аль нь дутуу болов гэдгээс үндэслэн тогтоож олно. Магадгүй бичил дүрслэлийг дутуу ойлгосноос /оношоо зөв тогтоосон бол/ хамаарч байгаа бол дахин давтан эргэж ажиллана гэсэн үг. Тухайн зохиолоос бичил дүрслэлийг эрж хайж олоод, бичил дүрслэл болохыг баталж тайлбарлах. Үүний тулд бичил дүрслэл гэж юу болох, хэрхэн бүтээдгийг авч үзэх.

Хэлний хэрэглээ гэдэг бол зохиолчийн зүгээс уншигчдад нөлөөлөхийн тулд хэрхэн холбоо тогтоож байгааг хэлнэ. Түүнийг судална. Үүнд:

1. Зохиолчийн үг сонголт: Уран дүрийн үгийн сангаас хийсэн сонголт хийгээд үгийн дуудлага, өнгө аясыг судална.
2. Өгүүлбэр зүйн ур маяг: Өгүүлбэрийн доторх үгийн байрлал хийгээд яруу хэрэглүүрийн үүргийг судлах
3. Дүрслэх хэлний хэрэглээ буюу дүрслэлийн ур маягийг судлах
4. Бичил дүрслэл буюу мэдрэхүйн нарийвчлалыг судлах

Бичил дүрслэл: Зохиогч санааг дамжуулж, өнгө аяс, уур амьсгалыг бүтээхийн тулд бичил дүрслэлийг хэрхэн ашигласныг тайлбарлана. Тайлбарлахдаа бичил дүрслэл нь мэдрэхүйн дүрслэлд тулгуурлаж байна уу, хийсвэр санаанд тулгуурлаж байна уу? гэдгийг ажиглана. Уран сайхны бичил дүрслэл нь бидний сэтгэл санааны байдлыг бүтээж, сэтгэл хөдлөлийг сэлгэж байдаг. Жишээ нь: “Гол ус намуухан урсана” гэхэд “намуухан” гэсэн дүрслэх үгээр сонорын мэдрэхүүд хандаж алгуур тайван үр нөлөөг бүтээсэн байна. /Г.Нандинбилиг “Эх зохиолыг задлан шинжилж, үнэлэх арга зүй” УБ2018 42-р тал/

П. Бадарч “Эхийн сэтгэл”

“...Тэмээ тэмээн цагаан үүлийг

Тэндээ царцтал харлаа

Тэнгэрийн ягаан хаяаг

Цав суутал хүүгээ ширтлээ

Ижийдээ ирсэнгүй ээ” гэсэн хэсэг уншигчийн сэтгэл санаанд нөлөөлж байгааг “царцтал харлаа”, “цав суутал ширтлээ” үгээр эх хүн үрээ ямагт хүлээж, уулзан учрахыг мөрөөсөж байдгийг дүрсэлжээ.

Судалж байгаа зохиолоос хамаарч бичил дүрслэлийн уншигчдад үзүүлж байгаа үр нөлөөг олж тайлбарлахын тулд сэтгэлийг хөдөлгөж, баяр баясал, хайр энэрэл, бардамнал, үзэн ядалт, гуниг, бухимдлыг төрүүлэх гэх мэтээр хэрхэн сэтгэл санаанд нөлөөлж байгаа хэсгийг олж тайлан тайлбарлана. Мөн чихэнд сонсголонтой, нүдэнд үзэгдэх тод дүрслэлтэй, аманд амтагдтал, гар баригдтал гэх мэт мэдрэхүүд нөлөөлж байгаа хэсгийг ч олж тайлбарлуулах дадлага хийснээр үр дүнд хүрнэ. Энэ мэтээр агуулгын хүрээнд хоцрогдож буй ойлголтоо эргэн давтан үзэх, дадал болгоход оношлох шалгалтын ач холбогдол оршино.

Явцын үнэлгээнд үнэлгээний шалгуурыг ашиглах

Хичээл сургалтын үйл ажиллагаандаа өдөр тутам явцын үнэлгээг хэрэглэдгийн учир нь сурагчдынхаа давуу болон сул талыг тодорхойлж, сурагчдыг ахиц дэвшил гаргах, сурах арга барил суулгах, сэтгэх чадварыг тэлэх, өөрийн удирдлагатай суралцахад нь дэмжлэг үзүүлэх зэрэг давуу талуудтай.

Явцын үнэлгээ нь сурах үйл ажиллагаанд дараах байдлаар дэмжлэг үзүүлдэг.

- Сурагчидтай суралцахуйн зорилгын талаар ярилцах
- Тэд юу мэдэж, чадаж байгааг ойлгох
- Чанартай гүйцэтгэл ямар байдаг, түүнд хүрэхийн төлөө яаж ажиллах, ямар арга зам байгааг ойлгоход туслах
- Өөрийн болон анги хамт олны үнэлгээг дэмжих
- Сурагчдын цаашид хийх алхмуудыг нарийвчлан чиглүүлсэн зөвлөмж /feedback/-ийг өгөх.

Явцын үнэлгээг өдөр бүр хичээл сургалтдаа хэрэгжүүлэх олон арга байдаг.

- Суралцагчдаас хүлээж буй үр дүнгүүдийг тэдэнд мэдээлэх
- Гол чухал ажлыг ялган танихад нь туслах
- Өөрийн ажлын сайжруулах шаардлагатай талуудыг тодорхойлоход туслах
- Хичээлийн турш ахиц дэвшлийг хянах
- Сурагчийн буруу ойлголтыг тодорхойлох
- Сурагчдад хоцрогдож байгаа зүйлээ тодорхойлоход нь туслах
- Амжилтыг урамшуулан сайшаах.

Хамгийн үр нөлөөтэй агаад сурагчийн ахиц дэвшилд хүргэж байдаг үнэлгээ бол яахын аргагүй явцын үнэлгээ юм. Явцын үнэлгээ бол анги танхимын үйл ажиллагааны нэг чухал бүрэлдэхүүн хэсэг бөгөөд тасралтгүй хэрэгжүүлснээр сурагчийн чадавхыг нэмж, ахиц дэвшилд хөтөлж байдаг билээ. Гагцхүү багш хөгжлийг дэмжигч, чиглүүлэгч байх ёстой. Үлгэрлэвэл: XI ангид “Зохиолын өгүүлэгдэхүүн ба зохиомжийн нэгжүүдийн уялдаа холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлох” суралцахуйн үр дүнг хэрэгжүүлэхдээ шалгуурт тохирсон ялгаатай даалгаврыг өгөх. Тийм учраас багш шалгуурын ялгааг сайтар ойлгох нь чухал юм.

<p>Зохиолын эхлэл, зангилаа, өрнөл, туйл, тайллын уялдаа холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлдог.</p>	<p>Зохиолын өгүүлэгдэхүүний уялдаа холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлохоос гадна зохиомжийн нэгж /хүүрнэл, байгалийн зураглал гэх мэт/-ийг олж тодорхойлдог.</p>	<p>Зохиолын өгүүлэгдэхүүн болон зохиомжийн нэгж /хүүрнэл, байгалийн зураглал, харилцан яриа, дотоод яриа гэх мэт/ -ийн уялдаа холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг бичиглэл /зураглал/ хийж тодорхойлдог.</p>	<p>Зохиолын өгүүлэгдэхүүн болон зохиомжийн нэгж /хүүрнэл, байгалийн зураглал гэх мэт/ ба хүүрнэлийн дуу хоолойн үүргийг утга санаанд нөлөөлж байгааг бичиглэл /зураглал/ хийж тодорхойлдог.</p>
--	---	--	--

I түвшний шалгуурт нийцсэн даалгавар бол мэдээж багаас ахлах хүртлээ уран зохиолын хичээлийн хүүрнэл зохиол /голдуу/-ын өгүүлэгдэхүүнийг зааглаж тэмдэглэх, товч хураангуйлж бичих чадвартай болсон байх бөгөөд ахлах ангийнхны хувьд бараг бүгд чадах байх. Гэвч зохиолын өгүүлэгдэхүүний уялдаа холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг тайлбарлаж тодорхойлно гэдэг бол зүгээр ганц нэг асуултад хариулах төдийхнөөр хязгаарлагдахгүй. Багш өгүүлэгдэхүүн бүрийн холбоо уялдааг тайлбарлуулахаас өгсүүлээд утга санаанд яаж нөлөөлж байгааг

тодорхойлуулна, сурагчаар бүтээлгэнэ.

II түвшний шалгуурт нийцсэн даалгавар зохиолын өгүүлэгдэхүүний холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг тайлбарлаж чадаж буй сурагчийг зохиолоос /хүүрнэл, байгалийн зураглал гэх мэт/ эрэлт хайлт хийж, олсныг судлуулж тодорхойлуулна.

III түвшинд зохиолын өгүүлэгдэхүүний холбоо нь утга санаанд нөлөөлж байгааг тайлбарлаж чадах тул /хүүрнэл, байгалийн зураглал, харилцан яриа, дотоод яриа гэх мэт/-ийг бичиглэл, зураглал хийж, утга санаанд нөлөөлж байгааг судлан тогтоож, тодорхойлуулах чадварын даалгавар өгнө.

IV түвшинд мөн зохиол өгүүлэгдэхүүнийг холбоо утга санаанд нөлөөлж байгааг тодорхойлж тайлбарлаж чадах тул зохиолын зохиомжийн хүүрнэл, байгалийн зураглал гэх мэтийг тодорхойлохоос гадна хүүрнэлийн дуу хоолойн үүрэг утга санаанд нөлөөлж байгааг бичиглэл /зураглал/-аар хийж тодорхойлуулах зэргээр гүйцэтгэлийг алхамчилж өгнө. Энэ мэтээр үнэлгээний шалгууруудыг тухайн нэг эх зохиол дээр үр дүнтэй хэрэгжүүлж чадвал дараа дараагийн зохиолыг

задлан шинжилж, тайлан тайлбарлах чадвар ахих болно. Тайлбарлана гэдэг бол нэгхэн үйлээр хязгаарлагдахгүй. Бодох, шалтгааныг олох, эргэцүүлэх, ярих, бичих гээд олон үйлдлүүдийн нийлбэр юм.

Уран зохиолын хичээлийн үнэлгээний шалгуурыг нэгж хичээлдээ хэрхэн хэрэгжүүлэх арга зүйн талаар:

Судлах зохиолын төрөл зүйл, агуулга, хэмжээнээс хамаарч ямар үр дүнд хэдийд хүрэхээ график төлөвлөгөө гарган ажиллах нь бидний ажилд тустай тул нэгэн ангийн жишээгээр үзүүлье. /XII ангийн сурах бичгийн агуулга-2019/

Үнэлгээний нэгж	Хугацаа Нэгж хичээл	I улирал						II улирал		III улирал		
		Монголын орчин үеийн яруу найраг			Монголын орчин үеийн өгүүллэг, тууж			Монголын орчин үеийн роман		Монголын орчин үеийн жүжиг		
Суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуур		“Мөнгөн хазаарын чимээ”, Нүүдэлчний намар”, “Туулын шугуй” Б.Я. “Эхийн сэтгэл” П.Б.	“Би тэнгэрийн хүү” Ш.С., “Шувуун зэл” Ч.Д. , “Сэлбэ” Ц. Ч.	“Өгсүүр замын дуу” Т.Г. “Эрх чөлөө” Ц. Х.	“Элбэг дээл” Ш.Г. “Өвгөн шувуу” С.Э.	“Бууж мордох хорвоо” С.Д, “Аквариум” Л.Ө.	“Хөгшин чоно ульсан нь” Д.Н, “Аянгат цагийн тууж” Ч.Г.	“Тунгалаг Тамир” Ч.Л.	“Оройгүй сүм” Л.Т.	“Учиртай гурван толгой” Д.Н	“Тамгагүй төр” Б. Л.	“Эцсийн тушаал” Д.Н.
Зохиолыг уншиж ойлгох	Зохиолыг хам сэдвийн хүрээнд тусган, эргэцүүлснээ илэрхийлдэг.	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Уншсан зохиолын хүрээнд үзэл бодлоо илэрхийлэн мэтгэлцдэг.		+		+	+	+	+	+	+	+	
	Хүний мөн чанар, нийгэм, соёлын тогтвортой хөгжлийг ойлгосноо илэрхийлдэг.				+	+	+	+	+	+	+	+

Зохиолыг задлан шинжлэх	Зохиолын зохиомж ба өгүүлэгдэхүүн бүтэц нь утга санаанд хэрхэн нөлөөлж буйг дүгнэдэг.				+	+	+	+	+	+	+	+
	Дүрийн хэв шинжийг тодорхойлж, утга санаанд нөлөөлж буйг тайлбарладаг.				+	+	+	+	+	+	+	+
	Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрд нөлөөлж буйг задлан шинжилдэг.		+	+	+	+	+	+	+	+	+	+
	Сэдэв, утга санаа, хам сэдвийн хамаарлаар далд утгыг тайлан тайлбарладаг.		+		+	+	+	+	+	+	+	+
	Зохиолын хэл найруулга, уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг дүгнэж, үнэлдэг.	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
	Зохиолын хэлний хэрэглээг задлан шинжилж, нэгтгэн дүгнэж бичихдээ жишээ, тайлбар, нэр томъёог хэрэглэдэг.				+	+	+	+	+	+	+	+
	Зохиолын хэл найруулгаас суралцан, дүрслэл ашиглаж, санаагаа төгсгөн зохиодог.				+		+		+			
	Зохиолын үг хэллэг, уран дүрслэл, яруу хэрэглүүрээс суралцан, уран сайхан илтгэдэг.	+	+	+	+	+	+	+	+	+	+	+
Шүлэглэсэн зохиол		+	+	+						+	+	
Яруу найргийн айзам, эгшиглэл, бадаглалыг задлан шинжилдэг	+	+	+							+	+	

Энэхүү хүснэгтэн мэдээлэл хамтын үйл ажиллагааг зорилго чиглэлтэй болгоход тустай. Өөрөөр хэлбэл хэдийд, ямар зохиолд суурилан, сургалтын дүнгийн шалгалт авч болох хийгээд хамтран боловсруулахад үүрэгтэй юм.

Жишээ нь: II улирлын төгсгөлд “Монголын орчин үеийн роман”-ыг үзэж дуусахад суралцахуйн үр дүнгийн үнэлгээний шалгуурын аль алиныг оруулж, ямар арга хэлбэрийг сонгох төлөвлөлт болно. Ийм байдлаар анги бүрээр судалж буй зохиолдоо тулгуурлан төлөвлөж болно.

Гурав. Нэгжийн үнэлгээний жишиг даалгавар

3.1. Үнэлгээний даалгавар боловсруулах нь:

Х ангийн Уран зохиолын эх зохиолыг уншиж агуулгыг ойлгосон үр дүнг үнэлэх даалгавар боловсруулах аргачлал, үндэслэлийг тайлбарлая. Ер нь нэг мэргэжлийн олон багш нартай сургуулийн заах аргын нэгдэл хамтран ярилцаж боловсруулалт хийх нь хамгийн үр дүнтэй.

Суралцахуйн үр дүн нь: Зохиолыг тусган хүлээн авснаа /амаар буюу бичгээр/ илэрхийлдэг болсон байна. Энэ нь гурван шалгууртай. Шалгуур тус бүр дөрвөн түвшинтэй. Шалгуур нь:

- ✓ Зохиолыг хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлснээ илэрхийлдэг.
- ✓ Уншсан зохиолын хүрээнд сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлдэг.
- ✓ Үндэсний ижилсэл, үнэ цэнт зүйлсээ ойлгосноо илэрхийлдэг.

Тэгвэл үр дүнд хүрэхийн тулд /үр дүнд хүргэхийн тулд/, идэвхтэй, судалгаат уншлага хэрэгтэй. Үүний тулд ганцаар болон хамтран унших нь нээлттэй. Сурагч уншсан зохиолыг тусган хүлээн авснаар /амаар буюу бичгээр/ юуг илэрхийлдэг болсон байх вэ? гэдгийг хүснэгтээс харьцуулалт хийж ажиглавал ялгаатай байдлыг мэднэ.

Анги	Шалгуурын түвшин			
	I	II	III	IV
10	Түүх, нийгэм, соёлын хам сэдвийн хүрээнд юуны тухай өгүүлснийг /ерөнхий ойлголт/ илэрхийлдэг.	Зохиолын доторх үг, өгүүлбэрт үндэслэн /түүх, нийгэм, соёл/-ын хам сэдвийн алинд хамаарч байгааг тогтоож, юуг тусган авснаа илэрхийлдэг.	Зохиолд /түүх, нийгэм, соёл/-ын хам сэдэвт ямар асуудал дэвшүүлсэн, ямар хэрэг явдлаар үзүүлснийг өөрийн үзэл бодол, байр суурьтай холбон илэрхийлдэг.	Зохиолд дэвшүүлсэн /түүх, нийгэм, соёл/-ын хам сэдэв юуг бодогдуулсан, далд /ил/ утгыг тайлж байгаа өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлдэг.
	Бусдын санал бодлыг хүлээцтэй сонсдог, сэтгэгдлээ илэрхийлдэг	Уншсан зохиолын хүрээнд асуулт тавьдаг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлдэг.	Уншсан зохиолын хүрээнд асуулт асууж, хариулт өгдөг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлдэг.	Уншсан зохиолын хүрээнд шүүмжлэн дүгнэлт өгдөг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлдэг.
	Зохиолын хэрэг явдлаас өөрт хэрэгтэй эерэг зүйлийн талаарх ойлголтоо илэрхийлдэг.	Зохиолын утга, агуулгаас өөрт болоод бусдад хэрэгтэй сургамж, үлгэрлэж болох зүйлийн талаарх ойлголтоо илэрхийлдэг.	Зохиолоос үндэсний онцлог ялгааг харуулж буй хэсгийг сонгосноо; утга, агуулгаас амьдрахуйд, ёс зүйтэй болоход үлгэрлэсэн чухал зүйл ойлгосноо илэрхийлдэг.	Зохиолоос үндэсний онцлог илэрсэн хэсгийг сонгож, нийтлэг ижилслийг; зохиолын утга, агуулгаас хүний амьдрал, зан чанар, бахархал зэрэг чухал зүйл ойлгосноо илэрхийлдэг.

- Зохиолыг хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлснээ илэрхийлдэг шалгуурын дээд түвшин нь зохиолд дэвшүүлсэн /түүх, нийгэм, соёл/-ын хам сэдэв юуг бодогдуулсан, далд /ил/ утгыг тайлж байгаа өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлэх чадвар юм. Сурагч энэ түвшинд хүрэхийн тулд юуг хийх ёстой вэ гэхээр эх зохиолоо бүрэн уншсан, түүний дагуу бүтээлч үйл ажиллагаа хийсэн, мөн зохиолоо өөрийн үзэл бодолтой холбон илэрхийлэх арга барилтай болсон байхаас гадна зохиолд үзүүлсэн орон, цаг болоод нөхцөл байдлыг, хам сэдвүүдийг ойлгосон байх. Өөрөөр хэлбэл нийгэм, түүх, соёлын нөхцөлүүд юм уу, нөхцөл байдлын онцлогийг ойлгосноо тайлан тайлбарлана. Тэгвэл багш сурагчаа хэрхэн үнэн зөв үнэлж дүгнэх вэ? асуудал бол бас л нарийн төлөвлөлт, менежменттэй холбоотой юм.
- Уншсан зохиолын хүрээнд сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлдэг шалгуурын дээд түвшин нь уншсан зохиолын хүрээнд шүүмжлэн дүгнэлт өгдөг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх юм. Сурагч энэ түвшинд хүрэхийн тулд бүтээлч /ажиглалт, судалгаатай/ уншлага хийсэн байх нь. Зохиолын хэрэг явдал, хүүрнэн өгүүлэгчийн мэдээлсэн орон, цаг, нөхцөл байдлын дунд бодгаль хүний санаа сэтгэл, үзэл бодолтой уншигч /өөрийгөө/ холбон санал, сэтгэгдлээ, зохиол дахь хэрэг явдал, үзэгдэл зэргээс нарийн гярхай мэдэрсэн мэдрэмжээ жишээ баримттай холбон ярьдаг, бусдыг сонсдог, бас хариулт өгч чаддаг байж гэмээнэ шалгуурыг хангана гэсэн үг.
- Үндэсний ижилсэл, үнэ цэнт зүйлсээ ойлгосноо илэрхийлдэг шалгуурын дээд түвшин нь зохиолоос үндэсний онцлог илэрсэн хэсгийг сонгож, нийтлэг ижилслийг; зохиолын утга, агуулгаас хүний амьдрал, зан чанар, бахархал зэрэг чухал зүйл ойлгосноо илэрхийлэх бөгөөд зохиолд үндэсний онцлог ялгааг үзүүлсэн хэсгийг олж нийтлэг ижилслийг тайлбарлана. Тайлбарлахдаа тухайн үндэстэн нь бусад үндэстнээс ялгарч байгаа ялгааг баримтаар тайлна. Зохиолын утга, агуулгаас хүний нийгмийн амьдрал, соёл, зан заншил, үзэл, хүний мөс, зан чанар, бахархал зэрэг чухал зүйл ойлгоно. Ийнхүү хувь хүнд улс үндэсний онцлог, хүний амьдрал, зан чанар, бахархал зэрэг мэдрэгдэж байгаа нь /бүтээл туурвил, соёл гэх мэт/, бас зохиолоос олж явсан

үнэт зүйлийг ярьж илэрхийлж байгаа нь хувь хүний үнэт зүйл болж байгаа юм. Ингэснээрээ уран зохиол нь нийгэм дэх хувь хүний төлөвшил, ёс суртахуун, бие хүн болоход хүчтэй нөлөөлдөг аж. Энэ нь суралцахуйн зорилтын төлөвшил, хандлага хэрэгжиж байгаа үйл явц болно.

3.2. Нэгж хичээлийн үнэлгээний даалгаврын жишээ:

10-р ангийн Уран зохиолын үнэлгээний I нэгж буюу “Зохиолыг тусган хүлээн авснаа /амаар буюу бичгээр/ илэрхийлдэг болсон байна” хүрээнд рубрик ашиглан хэрхэн үнэлэх тухай зөвлөмжилье. Үүний тулд “рубрик” (Rubric) -ийн талаарх ойлголтыг хүргэе.

Рубрик гэдэг нь сурагчийг амаар, бичгээр, ажлын хуудсаар үнэлж болох үнэлгээний хэрэгсэл юм. Сурагчдыг оноожуулж үнэлгээ өгч байгаа багшийн үйл ажиллагаа нь бодит дүнд хүрэхэд түлхэц болохоос гадна, тэднийг илүү бүтээлч, бие даах чадвартай болоход сайнаар нөлөөлдөг. Рубрикийн гол зорилго нь гүйцэтгэлийг үнэлэхэд оршино.

Хүссэн үр дүнд хүргэхийн тулд суралцагчийн эзэмших ёстой мэдлэг, чадвар, хандлагын жагсаалтыг гаргах.

Рубрик хийж, шүүн тунгааж, үнэлж дуусгасны дараа сургалтын үр дүн хэр байгааг дүгнэж /нэгж хичээлийн үр дүнг/ болдог. Өөрөөр хэлбэл багц шалгуур бүрд авсан оноогоор нь дүгнэж, ямар түвшинд байх ёстой вэ, ямар агуулга, ухагдахуун, мэдлэг гэх мэт дутуу байв гэдгийг үзүүлэлтүүдээс шинжилж болдог.

Рубрик нь багшийн хувьд сурагчдын эзэмших мэдлэг, чадвар, хандлагыг төлөвлөх, түүний амжилтыг тогтмол хянахад туслах хүснэгт байдаг. Мөн ээлжит болон нэгж хичээлийн үр дүнг тодорхойлох, үр дүн тус бүрийн үнэ цэнийг тогтоох, хүрсэн амжилтыг бүртгэх, үйл ажиллагаа хэрэгжүүлэх, арга хэрэгсэл юм.

Рубрик нь дор хаяж 3 түвшнийг тодорхойлсон шалгууртай байх бөгөөд түвшин бүр нь өөрийн гэсэн багц шалгууртай байна.

Рубрикийн босоо шугам- Шалгуурууд, Хэвтээ шугам- Чанарын түвшинг илэрхийлнэ. Рубрикийн төрлүүд:

1. Аналитик рубрик: Энэ рубрик нь гарах бүтээгдэхүүн болон үйл явцын хэсэг тус бүр эсвэл тодорхой зүйлийг олон баганаар дүрсэлдэг.
2. Дараалсан рубрик: Рубрикийг сургалтын нэг үр дүнгийн ахицыг тасралтгүй харахын тулд хэрэглэдэг. Жишээ нь: Тухайн сурагчийн долоо хоног бүрийн ахицыг тооцож тэмдэглэл хөтөлнө.
3. Үйл явцын рубрик: Сурагчдын гүйцэтгэсэн даалгаврын тайлбар, гүйцэтгэл, төлөвшил, хандлагыг оноожуулахад хэрэглэнэ. Жишээ нь, манлайлал, багаар ажиллах чадвар гэх мэт.

Рубрик боловсруулах зөвлөмж:

- Эхлээд хүмүүсийн боловсруулсан рубрикийг анхааралтай судлах
- Босоо чиглэлийн баганы эхний мөрөнд сурлагын өндөр түвшнийг бичих бөгөөд дор хаяж 3 шалгуур байх.
- Нэгж хичээлийн рубрикийг зохиохдоо ээлжит хичээл бүрээр эзэмших чадваруудыг багтаасан байх
- Рубрик нь сурагчдад нэгж хичээлийн хуваарь, сэдэв, болон суралцахуйн хүрээ болж өгөх учир сургалт эхлэхийн өмнө тэдэнд танилцуулах
- Шалгуураа шинжлэх ухааны хувьд оновчтой, бүх суралцагчдын хүрэх боломжтой түвшин бүрд тохирсон үгээр бичих
- Шалгуур жишиг даалгавартаа тохирч байгаа эсэхийг шалгах
- Өөрийн боловсруулсан рубрикийг сургалтад хэрэглэхээс өмнө сурагчид, багш нар, эцэг эхтэй ярилцах
- Зарим тохиолдолд сурагчидтайгаа хамтран рубрикээ боловсруулснаар тэдний хөгжилд дэмжлэг болно.

Рубрик үнэлгээний давуу тал:

- Рубрик ашиглан үнэлсэн тохиолдолд суралцагч үнэлгээнд сэтгэл дундуур байдаггүй.

- Үнэлгээний шалгуур тодорхой байдаг.
- Үнэлгээ хийсэн үндэслэлийг(feedback) тайлбарлах боломжтой учир шударга болдог.
- Сурагч шалгуураа биелүүлэхийн тулд бололцоогоо бүрэн дайчилдаг.
- Өөрийн болон багийн ажлын үнэлгээг өөрсдөө ч үнэлэх боломжтой.
- Сурагчийн идэвх оролцоо нэмэгддэг.
- Бие даан ажиллах чадвар нь ахидаг.
- Сургалтын үйл ажиллагааны явцад мэдлэгт суурилсан бүтээл хийх боломжтой.
- Багаар ажиллах болон бусадтай илэн далангүй бодлоо солилцох чадвар нь дээшилнэ.

10-р ангийн “Монголын нууц товчоо”

Үнэлгээний нэгж-1 Рубрик ашиглан оноожуулах аргачлал.

Зорилго: Зохиолыг тусган хүлээн авснаа амаар илэрхийлж буйг үнэлэх.

Багш үр дүнгийн үнэлгээний шалгуурыг урьдчилан танилцуулж, ганцаарчилсан болон баг, анги нийтийн уншлага хийсний дараа **илтгэл хэлэлцүүлж** оноожуулж үнэлнэ.

Агуулга: Илтгэл хэлэлцүүлнэ.

- “Монголын нууц товчоо” зохиолоос 2-5 хам сэдвийг сонгон авч /түүх, нийгэм, соёл/ хүрээнд бэлтгэж илтгэнэ.
- Зохиолоос үндэсний онцлог илэрсэн хэсгийг сонгож, нийтлэг ижилслийг **нэг жишээгээр харуулах**; зохиолын утга, агуулгаас хүний амьдрал /зан чанар, бахархал/ суралцсан зүйлийг **нэг жишээгээр тайлбарлана**.
- Бусдын илтгэлд сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлэн оролцоно.

Суралцахуйн үр дүнгийн шалгуур, гүйцэтгэлийн хүрэх түвшнийг рубрик болгон ашиглах боломжтой гэж үзэж байна. Шалгуур нь 1-4 оноотой ба энэ нэгжид 3 шалгуур байгаа учраас 1-12 оноо болно.

Гүйцэтгэл	ТҮВШНИЙ ШАЛГУУР			
	I	II	III	IV
Түүх, нийгэм, соёл хам сэдвийн хүрээнд тайлан тайлбарлаж илтгэх	Түүх, нийгэм, соёлын хам сэдвийн хүрээнд юуны тухай өгүүлснийг /ерөнхий ойлголт/ илэрхийлсэн.	Зохиолын доторх үг, өгүүлбэрт үндэслэн /түүх, нийгэм, соёл/-ын хам сэдвийн алинд хамаарч байгааг тогтоож, юуг тусган авснаа илэрхийлсэн.	Зохиолд /түүх, нийгэм, соёл/-ын хам сэдэвт ямар асуудал дэвшүүлсэн, ямар хэрэг явдлаар үзүүлснийг өөрийн үзэл бодол, байр суурьтай холбон илэрхийлсэн.	Зохиолд дэвшүүлсэн /түүх, нийгэм, соёл/-ын хам сэдэв юуг бодогдуулсан, далд /ил/ утгыг тайлж байгаа өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлсэн.
Оноожуулалт	0-1оноо	2 оноо	3 оноо	4 оноо
Үндэсний ижилсэл, үнэт цэнт зүйл /хандлага/	Зохиолын хэрэг явдлаас өөрт хэрэгтэй эерэг зүйлийн талаарх ойлголтоо илэрхийлсэн.	Зохиолын утга, агуулгаас өөрт болоод бусдад хэрэгтэй сургамж, үлгэрлэж болох зүйлийн талаарх ойлголтоо илэрхийлсэн.	Зохиолоос үндэсний онцлог ялгааг харуулж буй хэсгийг сонгосноо; утга, агуулгаас амьдрахуйд, ёс зүйтэй болоход үлгэрлэсэн чухал зүйл ойлгосноо илэрхийлсэн.	Зохиолоос үндэсний онцлог илэрсэн хэсгийг сонгож, нийтлэг ижилслийг; зохиолын утга, агуулгаас хүний амьдрал, зан чанар, бахархал зэрэг чухал зүйл ойлгосноо илэрхийлсэн.
Оноожуулалт	0-1оноо	2 оноо	3 оноо	4 оноо
Илтгэлтэй холбоотой байр сууриа илэрхийлэх	Бусдын санал бодлыг хүлээцтэй сонсдог, сэтгэгдлээ илэрхийлсэн	Уншсан зохиолын хүрээнд асуулт тавьдаг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлсэн	Уншсан зохиолын хүрээнд асуулт асууж, хариулт өгдөг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, сэтгэгдэл, мэдрэмж, үзэл бодлоо илэрхийлсэн	Уншсан зохиолын хүрээнд шүүмжлэн дүгнэлт өгдөг, бусдын санал бодлыг хүлээцтэй сонсож, өөрийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлсэн
Оноожуулалт	0-1оноо	2 оноо	3 оноо	4 оноо

Дөрөв. Нотолгоонд суурилсан шинжилгээ хийх аргачлал

Ангийн сурагчдыг илтгэл бэлдсэн байдлаас хамааран сурагчдыг хоёр хувааж хэлэлцүүлж болно. Сурагчдын авсан онооны нэгтгэлээр сурагч бүрийн тухайн зохиолыг тусган хүлээж авсан үр дүн харагдахаас гадна, сургалтын үр дүн харагдана. Түүнд дүн шинжилгээ хийнэ.

Тухайн ангийг 30 сурагчтай гэж үзвэл:

Гүйцэтгэл	Түвшний шалгуур				Хувь
	I	II	III	IV	
Түүх, нийгэм, соёл хам сэдвийн хүрээнд тайлан тайлбарлаж илтгэх	1	9	13	7	66,67
Үндэсний ижилсэл, үнэ цэнт зүйл /хандлага/		5	15	10	83,33
Илтгэлтэй холбоотой байр сууриа илэрхийлэх	5	10	12	3	50,00
Нийт	6	24	40	20	
Хувь	6,67	26,67	44,44	22,22	

Хэвтээ шугамын үзүүлэлтээс дүгнэлт хийж, юуг анхааран ажиллах вэ? I, II түвшний эзлэх хувь 33, 34 байгаа нь энэ түвшнийг ахиулах эрэл хайгуул, арга барил хэрэгтэй юм. Өөрөөр хэлбэл I түвшний 6 сурагчийн сурах арга барилд өөрчлөлт оруулахын тулд эх зохиолыг дахин уншуулах, давтах, бусдаар тусламж дэмжлэг хүргэхээс өгсүүлээд олон арга замыг олно. II түвшний сурагчид нь хэдийгээр зохиолыг ойлгосон ч дутуу хандах, тайлбарлах чадвар дутмаг байгаад дүгнэлт хийж гүйцээн ойлгох, аливаад өнгөц биш гүн хандах арга барилыг бий болгох талаар зөвлөж туслах.

Харин босоо шугамын үзүүлэлтээс сурагч тайлбарлаж сурахын тулд зохиолын түүх, нийгэм, соёлын хам сэдэвт дэвшүүлсэн асуудлыг хэрхэн олох, түүнээс үүдсэн өөрт бодогдсон зүйл, далд /ил/ утгыг тайлан тайлбарлах арга,

түүнд уншигчийн зүгээс өгч буй үзэл бодол, байр сууриа илэрхийлэн чөлөөтэй ярьж сурах, сургах чадварыг эрэлхийлсэн чадвар хэрэгтэйг зөвлөнө. Мөн өндөр оноо авч чадсан 1-4 сурагчаар үлгэрлүүлэх нь ач холбогдолтой. Гэвч Үндэсний ижилсэл, үнэ цэнт зүйл /хандлага/ шалгуурыг 83,33 хувиар хангасан нь сурагчдын хандлага өндөр байгааг илтгэж байна. Өөрөөр хэлбэл тэд үндэсний онцлог болсон тэр үнэт зүйл зохиолд байгааг олж чадаж байна. Мөн бусдаас ялгарах ялгаа, ижилсэх нийтлэг шинжийг ойлгож байгаа төдийгүй уран зохиол хүний амьдрал, зан чанар, бахархал зэргээс чухал зүйл олж авч байгааг харуулж буй хэрэг болно. Чухамдаа үнэт зүйлийг ойлгож байна, бас өөртөө бий болгож байгаа.

Цаашилбал: Илтгэлтэй холбоотой байр сууриа илэрхийлэх гүйцэтгэл нь 50%-тай байгаа нь үнэндээ хувь хүний сэтгэхүйн чадвар, ярихуйн чадвар дундаж байгаа хэрэг. Тэгвэл нэгдүгээрт, бусдын илтгэж ярьж байгааг сонсоод оюун дүгнэлт хийх нь үнэхээр оюун тархинаас их зүйл шаардана. Иймийн тулд идэвхтэй сонсогч байх талаар зөвлөх. /би л ярьсан бол болно, бусад нь хамаагүй гэх эсвэл одоо боллоо гэх хувиа хичээсэн үзэл гэх мэтийг гаргуулахгүй байх/ Хоёрдугаарт: Өрөөлийг хүндэтгэн үзэх үзэлтэй болгоход туслах. /Түүний уншиж, судалж, мэдсэнийг нь, илүү хөдөлмөрлөснийг нь үнэлж харьцах ёс зүйтэй болгоход багш л гол үүрэг гүйцэтгэнэ. Хэн нэгнийгээ ярьж байхад яриаг таслахгүй байх, “уучлаарай”, “баярлалаа” гэх үгс хэлүүлж сургах/ Гуравдугаарт: Уншсан зохиолын хүрээнд явуулж буй хэлэлцүүлэгт **шүүмжлэн дүгнэлт өгөх** ганц шүүмжилчхээд байдаг чадвар биш, өөрөө бүтээлч уншсаны үр дүнд бий болдог гэдгийг ухамсарлуулах. Дөрөвдүгээрт: Үзэл бодлоо илэрхийлэхдээ ерөнхий биш аль болох эшлэл, жишээ, баримт, нотолгоотой хэлж байхыг зөвлөх. Үүний тулд тухайн зохиолын үг хэллэгийг цээжлэх, зохиолын хэсгийн тоймлон өгүүлэхдээ зураг, схем ашиглах тухайн баримт жишээтэй холбоотой бусад судалгааны бүтээлтэй харьцуулах, жиших, эш үндэстэй эх сурвалжийг дурдаж ярих.

Ийнхүү рубрик нь нотолгоонд үндэслэн суралцагчдын сурах арга барил болон мэдлэг, чадвар, хандлагыг хэрхэн илэрч байгаад дүгнэлт хийх, тайлан бичихэд дэмтэй болдог байна. Нөгөө талаар сурагчийн манлайлал, хандлага, төлөвшлийг рубрикээс харж тооцоход ч хэрэг болдог.

Бичгийн ажлын шалгалтын агуулгыг боловсруулах:

10- р анги: “Монголын эртний уран зохиол-Монголын нууц товчоо”

Сурагчид монголын эртний түүхэн зохиолын хам сэдвийн хүрээнд тусган эргэцүүлж, үндэсний ижилсэл хийгээд үнэт зүйлсээ ойлгох /10.1а/ суралцахуйн зорилтын нэг хэмжүүр болох “Зохиолыг тусган хүлээн авснаа /амаар/ илэрхийлдэг болсон байна” гэсэн үр дүнг хэрхэн үнэлэх тухай дээр тайлбарласан. Харин бичгийн ажлаар сурагчдыг үнэлэхдээ “Зохиолыг задлан шинжлэх” үнэлгээний нэгжид тулгуурлан бичгийн даалгавар боловсруулах аргачлал, үндэслэлийг авч үзье. Ингэхдээ олон багш нартай сургуулийн багш нар хамтран ярилцаж боловсруулалт хийх нь хамгийн үр дүнтэй.

Суралцахуйн үр дүн нь:

- Зохиолын бүтэц, хүүрнэлийн холбоо хамаарал ба дүрийн шинжийг тайлбарладаг болсон байна.
- Зохиолын орчин нь дүрд нөлөөлж буйг тодорхойлдог болсон байна.
- Зохиолын уншигчид үзүүлэх нөлөө ба далд утгыг тайлан тайлбарладаг байна.
- Зохиолын хэл найруулгын нөлөө ба хэлний хэрэглээг үнэлж дүгнэдэг болсон байна.

Шалгуур нь:

- Зохиолын өгүүлэгдэхүүн бүтэц, хүүрнэлийн холбоо хамаарлыг тайлбарладаг.
- Зохиолын бодит ба хийсвэр дүрийг тайлбарладаг.
- Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрд нөлөөлж буйг тодорхойлдог.
- Сэдэв, утга санаа, хам сэдвийн хамаарлаар далд утгыг тайлан тайлбарладаг.
- Зохиолын хэл найруулга уран дүрслэл, яруу хэрэглүүр, бичил дүрслэлийн уншигчдад үзүүлэх нөлөөг тайлдаг.
- Зохиолын хэлний хэрэглээг үндэслэлтэй, баримт нотолгоотой, үнэлж дүгнэн бичдэг.

Тэгвэл гүйцэтгэлийн хүрэх түвшин өөрөө Блумын таксономийн танин мэдэхүйн түвшинд тулгуурласан учраас Блупринт зохиоход их дөхөм юм.

Блупринт гэж юу вэ?

Танин мэдэхүйн түвшнүүдээр даалгавруудынхаа тоог тогтооно. Өөрөөр хэлбэл үнэлэх төсөл зохионо. Ямар хичээлийн, хэддүгээр ангид, ямар төрлийн, юуны шалгалтыг, хэзээ, ямар хэлбэрээр, юунд тулгуурлан авсан нь тодорхой байдаг. /хүснэгтээр үзүүлбэл/

Шалгалтын төрөл	Уран зохиолын “Монголын эртний уран зохиол-Монголын нууц товчоо” нэгж хичээлийн шалгалт				
Анги	10				
Хугацаа	60 минут				
Шалгалтын хэлбэр	Бичгийн ажил				Огноо
Таксономи /Блум/	Сэргээн санах, ойлгох	Хэрэглэх /холбох/	Задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх	Үнэлэх, бүтээх	Даалгаврын тоо
Даалгаврын тоо	2	3	3	2	10
Хэсэг I	2	3	3	1	9
				1	1
Түвшний эзлэх хувь	20%	30%	30%	20%	100

Үнэлгээний хүрэх түвшин, хичээлийн агуулга, сурах бичгийн агуулга, хүүхдүүдийн бие даан уншсан чадвар, ойлголт мэдлэг, тайлан тайлбарлах чадвар зэргээс шалтгаалан асуулт даалгавраа хүнд хөнгөнийг үндэслэлтэй сонгож боловсруулна.

- 1. Шалгуурын төгсгөлд байгаа үйл үгийг ашиглах** /тайлбарладаг, тодорхойлдог, тайлан тайлбарладаг, уншигчдад үзүүлэх нөлөөг тайлдаг, үнэлж дүгнэдэг гэх мэт/
“Зохиолын орчин нь дүрд нөлөөлж буйг тодорхойлдог болсон байна” үр дүнгийн “Зохиолын гадаад ба дотоод орчин нь дүрд нөлөөлж буйг тодорхойлдог” шалгуурын I “сэргээн санах” түвшнийг илрүүлэх асуултыг боловсруулна.
- 2. Шалгуур нь хэдийгээр “тайлбарлах” байлаа ч агуулгын гүнзгийрэл, гүйцэтгэлээс хамаарч хэрэглэх эсвэл үнэлэх бүтээх түвшний даалгавар болж болох талтай.** “Зохиолын бодит ба хийсвэр дүрийг тайлбарладаг” шалгуурын

“Дүрийн хэлсэн үг, хийсэн үйлдлээс нөхцөл байдлыг тайлбарладаг” гэдгийг шинжлэхэд “хэрэглэх холбох” түвшний даалгавар болно. Жишээлбэл:

Бодончар, Буха хатаги ахын хойноос даган хатирч өгүүллүүн: “Ах аа, ах аа, бие тэргүүтэй, дээл захтай нь сайн” /МНТЗ/ гэсэн үгийг тухайн нөхцөл байдалтай холбон тайлбарлаарай гэвэл тэд иргэний ахуй байдал, аж төрөлтэй холбож илэрхийлэх учраас тэр. Тиймээс шалгалтынхаа даалгаврын /тавил/ асуултаас хамаарч аль түвшний асуултаар шалгаж, яаж оноожуулах вэ? гэдэг бол үнэндээ биднээс ихээхэн чадвар шаардаад байгаа юм.

IV түвшинд “Бодит ба хийсвэр дүрийн шинжийг зорилго, хүсэл эрмэлзэл, үг, үйлдлээс нь; зохиолын сэдэв, утга санаанд хэр нөлөөлснийг; нөхцөл байдалд татан оруулж буй шалтгааныг; дүр бүтээснээрээ уншигчдад юуг хэлэхийг хүссэнийг тайлбарладаг” шалгуурынхаа дагуу асуултаа сурагчдад ойлгомжтойгоор найруулах хэрэгтэй. Жишээлбэл: Бодончар, Буха хатаги ахын хойноос даган хатирч өгүүллүүн: “Ах аа, ах аа, бие тэргүүтэй, дээл захтай нь сайн” /МНТЗ/ гэсэн үг нь утга санаанд хэр нөлөөлснийг тайлбарлаарай гэвэл сурагчаас нэлээд олон зүйлийг шаардаж хариулах юм.

Бодончар урагт эс тооцогдон “гол дайрт, годил сүүлт орогшин хул морио унаж үхвэл үхье, амьдарвал амьдаръя” гэж одохдоо өдөр бүр тэр иргэнд очиж цэгээ гуйж уухдаа тэдний байдлыг гүнзгий судалж, Түнхэлэг горхиноо бүхий иргэнд эзэнгүй, их бага, сайн муу, толгой шийр цөм нэгэн адил чацуу буюу толгойлогчгүй байгааг анзаарч мэдсэний үндсэн дээр хялбар эзэлж болохыг “бие тэргүүтэй, дээл захтай нь сайн” үгээр илэрхийлсэн бөгөөд зохиолын утга санаанд захирах, захирагдах ёс, нийгмийн байгууллын үзэл санааг илэрхийлжээ мэтээр хариулах нь үнэлэх бүтээх түвшний гүйцэтгэл болно. Нөгөө талаар бодит дүрийн үг, үйлдлээр дамжуулан тайлан тайлбарлаж байгаа чадвар болно.

Үнэлгээний марк схем гэж юу вэ?

Багш шалгалтын асуулт даалгавар зохиох явцдаа оноог тооцож, хариултыг заавал зэрэгцүүлж хийх нь маш ач холбогдолтой. Учир нь сурагчаас ирэх хариултыг урьдчилан тооцоолсноороо бичгийн ажлыг засах оноожуулахад хялбар болдог. Өөрөө хийж буй учраас алдаа мэдгээ хянаана. Даалгаврын тохирц сайн болдог. Нэмэлт тайлбар хэсэгт санаагаа өөр хувилбаар хариулж болох эсэх, оноожуулах, эс оноожуулахыг тайлбар бичнэ.

Асуултын дугаар	Оноо	Хариулт	Нэмэлт тайлбар
1	1	<input type="checkbox"/> Хэдэн хүүхдээ өсгөж өндийлгөсөн гадаад орчин нь болж байна. <input type="checkbox"/> “бэлбэсэн” гэсэн үг нь ганцаар гэсэн утгыг илэрхийлж буй бөгөөд хатуужуулсан орчин нь Онон болно.	Хүүхдүүд Өэлүн үжин, Онон мөрөнхоёрыг холбоод өөрөөр тодорхойлж болно. Үүнтэй логикийн хувьд тохирсон бусад хувилбаруудыг тооцно.
2	2	<input type="checkbox"/> Тэд иргэний ахуй байдал, аж төрлөө хийхдээ толгойлогчгүй дур зоргоороо байдлыг ажсан <input type="checkbox"/> Тэр иргэнд очиж цэгээ гуйж уухдаа тэдний байдлыг ажиглаж ижил болохыг мэдсэн <input type="checkbox"/> Түнхэлэг горхиноо бүхий иргэнд эзэнгүй, их бага, сайн муу, толгой шийр цөм нэгэн адил чацууг мэдсэн гэх мэт хариултыг зөвд тооцож оноожуулна	
9	4	<input type="checkbox"/> Бодончар урагт эс тооцогдон “гол дайрт, годил сүүлт орогшин хул морио унаж үхвэл үхье, амьдарвал амьдаръя” гэж одохдоо өдөр бүр тэр иргэнд очиж цэгээ гуйж уухдаа тэдний байдлыг гүнзгий судалж, Түнхэлэг горхиноо бүхий иргэнд эзэнгүй, их бага, сайн муу, толгой шийр цөм нэгэн адил чацуу буюу толгойлогчгүй байгааг анзаарч мэдсэний үндсэн дээр хялбар эзэлж болохыг “бие тэргүүтэй, дээл захтай нь сайн” үгээр илэрхийлсэн бөгөөд зохиолын утга санаанд захирах, захирагдах ёс, нийгмийн байгууллын үзэл санааг илэрхийлжээ гэх мэт	Бодончар, Буха хатаги ахын хойноос даган хатирч өгүүллүүн: “Ах аа, ах аа, бие тэргүүтэй, дээл захтай нь сайн” /МНТЗ/ гэсэн үг нь утга санаанд хэр нөлөөлснийг тайлбарлахдаа бүрэн хандаагүй, найруулгын алдаа гаргаснаас хамааран оноог хасаж тооцно.

Бичгийн ажлаар сурагчийг үнэлэхдээ энэ мэтээр хандаж, үр бүтээлтэйгээр “Үнэлгээний сан” бүрдүүлбэл дахиж хянаж сайжруулах л үлдэнэ. Харин асуулт даалгавар нь оновчгүй, хэт ерөнхий, эсвэл бүтээлч биш хандвал олон дахин ажил болно.

НЭР ТОМЬЁО, ТАЙЛБАР:

Далд утга /Implied meaning/: Зохиолын өгүүлэмжээр дамжин шууд илэрдэггүй, тусгай судалгаа, тайлал, тайлбар шаарддаг гүн бүтэц дэх утгыг хэлнэ.

Зохиогч /Author/: Зохиолч, кино бүтээгчид гэх мэт уран бүтээлийн үүсгэн бүтээгчийг хэлнэ.

Зохиогчийн дуу хоолой /Author`s voice/: Зохиолчийн хувийн итгэл үнэмшил, ертөнцийг үзэх үзэл, үнэт зүйлийн чиг баримжаа, байр суурь, өөрийн үгээ илгээж буй арга.

Орчин /Setting/: Зохиолын үйл явдал болж байгаа орон ба цагийг орчин гэнэ. Орчинд цаг, орон, нарийн ширийн зүйлс болон нөхцөл байдлын дундах шалтгааныг авч үзнэ.

Өнгө аяс /Tone/: Зохиолыг хүлээн авсан уншигчийн сэтгэл санаанд нөлөөлж буй байдал.

Сэдэв /Theme/: Бичвэрийн үндсэн санааг авч үзнэ. Эхэд дэвшүүлсэн асуудал буюу юуны тухай бичсэн үндсэн суурь мэдээлэл.

Тайлан тайлбарлах бичвэр /Interpretive texts/: Бичвэрийн анхны зорилго бол дүр, үйл явдал, санаа, илэрхийлэл, үзэл баримтлал зэргийг тайлбарлах ба тайлах явдал болно. Үүнд өөрийн ба бусдын намтар, хэвлэл мэдээллийн өгүүлэл, баримтат кино болон бусад уран сайхны бус бичвэрүүд хамаарна.

Төрөл зүйл /Genre/: Бичвэрийн түүх болоод утгыг харгалзсан ангилал. Жишээ нь: адал явдалд, хайр дурлалын, шинжлэх ухааны, зөгнөлт зохиол гэх мэт. Мөн хэлбэр бүтцээр нь ангилна. Жишээ нь: яруу найраг, өгүүллэг, намтар гэх мэт.

Уран зохиол /Fiction/: Уран сэтгэмжээр ургуулан зохиож, уран сайхны хэл найруулгаар бүтээсэн, үйл явдал бүхий өгүүлэлт зохиол. Өгүүллэг, тууж, туульсын найраглал гэх мэт шүлэглэсэн ба үргэлжилсэн үгийн аль ч хэлбэрээр байна.

Уур амьсгал /Atmosphere/: Дүрүүдийн хоорондох харилцаанаас уншигчийн хүлээж авч буй мэдрэмжийг уур амьсгал гэнэ. Уур амьсгал нь орчныг бүтээх бичлэгийн сэтгэл хөдлөл юм уу, сэтгэл санааны байдлыг авч үзнэ.

Утга санаа /Main idea/: Тухайн зохиолын үйл явдлаар дамжин илэрч байгаа үндсэн дүгнэлт.

Үзэл санаа /Point of view/: Бичвэр дэх дүрийн ба зохиогчийн үзэл бодол.

Хам сэдэв/ Хам бичвэр /Context/: Бичвэрийн дотор үзүүлсэн орон, цаг болоод нөхцөл байдлыг хам сэдэв гэнэ. Хам сэдэв ерөнхийдөө нийгэм, түүх, соёлын нөхцөлүүд юм уу, нөхцөл байдлын онцлогийг харуулна. Хам сэдэв нь санааг ойлгох явцад уншигч сонсогчдын дурдсан танил бус үгийн хэрэглээгээр илэрнэ.

Хандлага /attitude/: Нөхцөл байдал, дүр, санааны тухай үзэл бодлын арга зам. Жишээ нь: Зохиогч ба хүлээн авагч хэн нэгэн юм уу, ямар нэгэн зүйлээр сөргөлдөх юм уу, туслах магадлал.

Хувиргасан бичвэр/ хувиргасан бүтээл /Transformation text/: Бичвэрийн анхны хэлбэрийг өөрчилсөн бичвэр. Тайз дэлгэцийн бүтээл, хялбаршуулсан бичвэр болон аман зохиолын хувилбар бичвэрүүд.

Бодит дүр: Түүхэн цаг үед байсан дүрээс эх авч гаргасан дүр.

Түүхэн дүр: Уран зохиолын бүтээлд уран дүрийн түвшинд боловсруулсан уран сайханжсан баримтат дүрийг түүхэн дүр гэнэ. Түүхэн дүр бүхэн бодит дүр мөн боловч бодит дүр бүхэн түүхэн дүр байж чаддаггүй.

Хийсвэр дүр: Бодитой бус, санаа сэтгэлийн хий дүрийг хийсвэр дүр гэдэг.

Дүрийн бодгаль шинж: Тухайн дүрд байх давтагдашгүй шинжийг хэлдэг

Дүрийн нийтлэг шинж: Тухайн цаг үе, нийгмийн хүрээний олон хүнд байдаг зан чанар ааш авирыг нэг дүрд шингээж дүрслэхийг хэлдэг.

Бодит ба хийсвэр дүр, дүрийн бодгаль ба нийтлэг шинж нь утга санаанд хэрхэн нөлөөлдөг вэ? Дүрүүд харилцаанд орж зөрчил үүсгэнэ. Хэрэг явдал, үйл явдлын цогц байдлыг бий болгоно. Дүрийн өсөлт өөрчлөлт, бууралтыг харуулна.

Үндэсний ижилсэл: Үндэстэн гэдэг бол хэл, газар нутаг, эдийн засаг, соёлын нийтлэг байдалтай ард түмэн юм. Ижилсэл гэдэг нь англи хэлний “Identity” (ижилсэл) гэсэн үг юм байна. Үндэсний ижилсэл гэдгийг хялбар тодорхойлбол хүн өөрийгөө аль нэг улс, үндэстэнд хамааруулан ойлгох тэр мэдрэмж, шинж тэмдгийг хэлдэг ажээ. Тэнгэр ивээлээ, тэнгэр өршөөг, тэнгэртээ залбирья гэж тэнгэрээ дээдэлдэг нь монголчууд. Хөх тэнгэр, хөх толбо, хөх бичиг гэж ярьж ойлгодог нь мөн л манай монгол үндэстэн. Үүнийг л үндэсний ижилсэл гэж үздэг аж. Үндэсний ижилсэл нь бусад үндэстнээс ялгарах ялгарал болдог.

Хүүрнэн өгүүлэгч: Зохиолын өгүүлэгдэхүүн болоод орон цагийг танилцуулж буй хүн. Нэгдүгээр биеэс буюу өгүүлэгч нь өөрөө тухайн зохиолын баатар мэтээр үйл явдлыг хүүрнэдэг. Гуравдугаар биеэс буюу болж буй үйл явдлыг хөндлөнгөөс харж буй хүний үүргээр, эсвэл бүхнийг мэдэгчийн байдлаар хүүрнэдэг. Хоёрдугаар биеэс буюу хоёр биеийн харилцан яриагаар үзүүлнэ эсвэл захидлын хэлбэрээр үзүүлнэ.

Үнэ цэнт зүйлс:

Үнэ цэнт зүйлс нь харьцангуй ойлголт бөгөөд гагцхүү үүгээр тодорхойлогдохгүй юм гэдгийг сайн ойлгоорой. Зохиолд үндэсний онцлог ялгааг үзүүлсэн хэсэгт тулгуурлан нийтлэг ижилслийг /соёл, зан заншил, үзэл, хүний мөс чанар/ ойлгосноороо тухайн үндэстэн нь бусад үндэстнээс ялгарч байгаа ялгаа нь үндэсний үнэт зүйлийн нэг болно. Зохиолын утга, агуулгаас хүний амьдрал, зан чанар, бахархал зэрэг чухал зүйл ойлгож, эх орон, түүх, соёл, хэл, байгаль, өв уламжлалаараа бахархаж, түүнийг хайрлан хамгаалахыг эрмэлзэж буй байдал нь, басхүү өөрийн үзэл бодлоо илэрхийлэн оролцож байгаа нь хувь үнэт зүйл болж байгаа юм. Уран зохиол нь ингэж нийгэм дэх хувь хүний төлөвшил, ёс суртахуун, бие хүн болоход хүчтэй нөлөөлдөг аж. Энэ нь ч бас үнэ цэнт зүйлийн нэг.

Зохиогчийн үг сонголт:

Уран дүрийн үгийн санд ойролцоо үг, ижил үг, эсрэг үг, хуучин үг, шинэ үг, харь үг, нутгийн аялгууны үг, мэргэжлийн үг, этгээд үг, бүдүүлэг үг, төсөөт үг, тонгоруу үг, өвөрмөц хэлц зэргийг сонгон хэрэглэхдээ зохиолч уншигчтайгаа хэрхэн холбоо тогтоосныг тайлбарлана.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ:

- Уран зохиолын хичээлийн сургалтын үр дүнг үнэлэх шалгуур /Бүрэн дунд боловсролын түвшин/-2021
- “Уран зохиол” сурах бичиг 10,11,12
- “Бүрэн дунд боловсролын хөтөлбөр” сайжруулсан хоёр дахь хэвлэл
- “Ерөнхий боловсролын сургуулийн уран зохиолын сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамж”- бүрэн дунд боловсрол 10,11,12, анги
- “Сургалтын хөтөлбөрийг дэмжих арга зүйн зөвлөмж”-Монгол хэл, Үндэсний бичиг, Уран зохиол X-XII УБ 2020,
- “Блумын таксономийн танин мэдэхүйн түвшин, мэдлэгийн төрлүүд”
- “Сонгох-хариултат даалгаврыг шинжлэх арга зүйн нэгэн хувилбар” лекц
- “Сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлал” РР
- “Үнэлгээний шалгуур боловсруулах нь” РР
- Г. Нандинбилиг “Эх зохиолыг задлан шинжилж үнэлэх арга зүй” УБ 2018
- Н. Батбаяр “Үнэлгээний онол арга зүй- эх хэл” УБ 2017

ЕБС-ийн Уран зохиол хичээл, сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх зөвлөмж боловсруулсан ажлын хэсэг:

Н.Батбаяр 33-р сургуулийн багш, тэргүүлэх, магистр

Хөндлөнгийн шинжээч:

Ө.Цэндсүрэн Монгол улсын гавьяат багш

Техникийн редактор:

Т.Отгон-Эрдэнэ Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, тэргүүлэх зэрэгтэй
Ш.Сувдмаа Боловсролын үнэлгээний төвийн мэргэжилтэн, магистр

Хэвлэлийн эх бэлтгэсэн дизайнер:

С.Мөнхмаа Интерпресс ХХК-ийн дизайнер, магистр

Цаасны хэмжээ: А4

Хэвлэлийн хуудас: 4 х.х

Дэлгэрэнгүй мэдээллийг:

www.eec.mn



Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 6-р хороо,
Энхтайваны өргөн чөлөө, Оюуны ундраа группын байр,
Утас/Факс: 976-11 7011- 8486
И-майл: info@eec.mn Вэб: www.eec.mn